

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж

ТООЦООНЫ

ГИШҮҮНЭЭР

ЭЛСЭХ ГАРЫН

АВЛАГА

Хөгжилд Хамтдаа

АГУУЛГА

Удиртгал	3
Гишүүнээр элсүүлэх үе шат	3
Тооцооны гишүүний шалгуур	4
Бүрдүүлэх баримт бичиг	4
Тооцооны ерөнхий болон шууд гишүүний хүлээх үүрэг	5
Тооцооны гишүүнчлэлийн шимтгэл хураамж	6
Тооцооны гишүүнээр элсүүлэх шийдвэр гаргах	6
Тооцооны гишүүнээр гэрээ байгуулах	6
Сургалт	6
Биржийн журмууд	7
Холбоо барих	7

УДИРТГАЛ

Энэхүү гарын авлага нь Биржийн арилжааны гишүүнээр элсэх өргөдөл гаргагчид чиглэл, зөвлөмж өгөх зорилготой болно.

ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ҮЕ ШАТ



Тооцооны гишүүний шалгуур хангах

Биржийн холбогдох журамд заасан шалгуурыг хангах шаардлагатай.



Бичиг баримт бүрдүүлэх

Холбогдох бичиг баримтыг өргөдөл хянах хураамжийн хамт Биржид хүргүүлнэ.



Тооцооны гишүүнээр элсүүлэх

Бичиг баримтыг Төв Клиринг хүлээн авч дүгнэлт гарган ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн ажлын 30 хоногт багтаан шийдвэр гаргана.



Гэрээ байгуулах

ТУЗ-ийн шийдвэр гарсны дараа 2 тал гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна. Элсэлтийн болон жилийн хураамж төлнө.

I ТООЦООНЫ ГИШҮҮНИЙ ШАЛГУУР

Тооцооны ерөнхий болон шууд гишүүн болохоор хүсэлт гаргагч нь дараах шалгуурыг хангасан байх бөгөөд тооцооны гишүүнчлэлтэй байх хугацаанд тогтмол хангаж ажиллана. Үүнд:

	Тооцооны ерөнхий гишүүн	Тооцооны шууд гишүүн
Ерөнхий шалгуур	Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх	
	Санхүүгийн зохицуулах хорооны журамд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн болон мөнгөн хөрөнгийн шалгуур хангасан байх	
	Үнэт цаасны тооцооны үйл ажиллагаа гүйцэтгэх санхүүгийн, хүний нөөцийн болон техникийн чадамжтай байх	
	Барьцаа хөрөнгө, дэнчинг заасан хугацаанд байршуулах чадамжтай байх	
	Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөтэй байх	
Нэмэлт шалгуур	Төв клирингтэй гэрээ байгуулсан төлбөр гүйцэтгэгч банканд харилцах данс нээлгэсэн байх	Биржийн гишүүнчлэлтэй брокер байх

I БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Биржийн тооцооны ерөнхий болон шууд гишүүнээр элсэх өргөдөл гаргагч нь дараах баримт бичгийг Төв клирингд ирүүлнэ. Үүнд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар, дүрэмд оруулсан боловч улсын бүртгэлд бүртгэгдээгүй байгаа нэмэлт өөрчлөлт
- Тооцооны ерөнхий гишүүн бол 3 (гурв)-аас доошгүй жилийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө
- Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан
- Хүсэлт гаргагчийн дотоод үйл ажиллагааг зохицуулсан журам, харилцагчтай байгуулах гэрээний төсөл
- Хувь нийлүүлэгч болон толгой, охин компанийн тухай мэдээлэл, энэхүү холбоо хамаарлыг нотлох холбогдох баримтуудын хуулбар
- Төв клирингтэй харилцах ажлыг хариуцсан ажилтны тодорхойлолт, танилцуулга, анкет
- Санхүүгийн баримт бичиг дээр гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар

ТООЦООНЫ ЕРӨНХИЙ БОЛОН ШУУД ГИШҮҮНИЙ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

Тооцооны ерөнхий болон шууд гишүүд нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:

- Төлбөр гүйцэтгэгчтэй банктай гэрээ байгуулж, төлбөр тооцооны гүйцэтгэхэд шаардлагатай харилцах данс нээлгэх
- Төлбөрийн агенттай гэрээ байгуулж, үнэт цаасны болон бэлэн мөнгөөр хийгдэх төлбөрийн даалгавар илгээх
- Харилцагчийн төлбөрийн үүргийг хүлээх
- Үнэт цаас зээлэх болон репо хэлцэл хийх
- Барьцаа хөрөнгө, дэнчинг байршуулах
- Өөрийн харилцагчаас барьцаа хөрөнгө болон дэнчин шаардах
- Харилцагчийн үнэт цаасны болон бэлэн мөнгөөр хийгдсэн төлбөр тооцооны бүртгэлийг хөтлөх
- Харилцагчаас үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамж тооцож нэхэмжлэх, түүнийг гаргуулах
- Өөрийн харилцагчийн арилжаа, төлбөр тооцоотой холбоотой мэдээллийн нууцлалыг хангах
- Төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдээллийг Төв клиринг, түүний системээс авах, тухайн мэдээллийн нууцлалыг хангах
- Төв клирингийн гишүүнчлэлийн шалгуурыг тогтмол хангаж ажиллах
- Төлбөр тооцооны үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлүүлэх

Тооцооны ерөнхий гишүүний хувьд дараах нэмэлт үүргүүдийг хүлээнэ. Үүнд:

- Журамд заасан цагийн хуваарь, нөхцөлийн дагуу төлбөр тооцооны үйл ажиллагаанд оролцох
- Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд зах зээлийн тогтвортой байдал, түүнд оролцогчдын эрх ашгийг хамгаалж ажиллах

ТООЦООНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ШИМТГЭЛ ХУРААМЖ

Хураамжийн нэр	Хэмжээ	Давтамж	
Өргөдөл хянах үйлчилгээний хураамж	500,000₮		
Элсэлтийн хураамж	Тооцооны шууд гишүүн	5,000,000₮	1 удаа
	Тооцооны ерөнхий гишүүн	10,000,000₮	
Жилийн хураамж	2,000,000₮	жилд 1 удаа	
Системд нэвтрэх эрхийн төлбөр	500,000₮	улиралд 1 удаа	
Хяналтын ажиллагааны хураамж	500,000₮	тухай бүр	

ТООЦООНЫ ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ ШИЙДВЭР ГАРГАХ

Тооцооны гишүүнээр элсэх шалгуур болон өргөдөл, баримт бичигт үндэслэн бүрэн хүлээлгэж өгснөөс хойш ажлын 30 (гуч) хоногт багтаан шийдвэр гаргана.

ТООЦООНЫ ГИШҮҮНЭЭР ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

Биржийн ТУЗ-ийн шийдвэрийг үндэслэн тооцооны гишүүний гэрээ байгуулах бөгөөд уг ажлыг Төв клиринг зохион байгуулна.

СУРГАЛТ

Бирж нь зах зээлийн үйл ажиллагааны оролцогчид Арилжааны болон тооцооны гишүүддээ зориулж тогтмол сургалт зохион байгуулдаг.

БИРЖИЙН ЖУРМУУД

	Журмын нэр	Тайлбар
1	Арилжааны журам	Арилжааны үйл ажиллагааны үндсэн зарчим болон арилжаанд оролцогчдын харилцааг зохицуулна.
2	Бүртгэлийн журам	Бүртгэлийн ажиллагааны үндсэн зарчим, оролцогчид, бүртгэлийн арга хэлбэр, өөрчлөлт болон үнэт цаас гаргагчтай холбоотой харилцааг зохицуулна.
3	Арилжааны гишүүнчлэлийн журам	Арилжаа гишүүнчлэлийн ажиллагааны үндсэн зарчим, элсэх үйл явц болон арилжааны гишүүдтэй холбоотой харилцааг зохицуулна.
4	Тооцооны үйл ажиллагааны журам	Төв клирингийн тооцооны үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж, төлбөр тооцооны оролцогчдын харилцааг зохицуулна .
5	Хяналтын журам	Үнэт цаас гаргагч болон биржийн гишүүн компани хууль тогтоомж дүрэм журам, үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих, хариуцлага тооцохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
6	Шимтгэл, хураамжийн журам	Биржийн үйлчилгээний хураамж шимтгэлтэй холбоотой харилцааг зохицуулна.

ХОЛБОО БАРИХ

Арилжаа гишүүнчлэлтэй холбоотой асуудал

Гишүүнчлэлийн мэргэжилтэн
info@ubx.mn

Төлбөр тооцоотой холбоотой асуудал

Клирингийн мэргэжилтэн
clearing@ubx.mn

Биржийн төлбөр тооцооны нэхэмжлэхтэй холбоотой асуудал

Нягтлан бодогч

Биржээс зохион байгуулж буй үйл ажиллагаатай холбоотой асуудал

Захиргаа, Бизнес хөгжлийн Газар

UBX **Ulaanbaatar**
Securities Exchange